


# АГУУЛГА


САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХАМГИЙН СҮҮЛИЙН ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ

**2-4**      **Бодлогын нийтлэл**

**5-7**      **Зохицуулалтын мэдээ**



**8-9**      **Ярилцлага**



**10-12**      **Тогтвортой санхүүжилт**



**13-14**      **Компанийн засаглал, комплайнс**




- ТҮЗ-ийн үйлдвэр, салбар, өргөтгөлөөс төвлөрч байгаа
- ТҮЗ-ийн үйлдвэр, салбар, өргөтгөлөөс төвлөрч байгаа
- ТҮЗ-ийн үйлдвэр, салбар, өргөтгөлөөс төвлөрч байгаа
- ТҮЗ-ийн үйлдвэр, салбар, өргөтгөлөөс төвлөрч байгаа
- ТҮЗ-ийн үйлдвэр, салбар, өргөтгөлөөс төвлөрч байгаа
- ТҮЗ-ийн үйлдвэр, салбар, өргөтгөлөөс төвлөрч байгаа
- ТҮЗ-ийн үйлдвэр, салбар, өргөтгөлөөс төвлөрч байгаа
- ТҮЗ-ийн үйлдвэр, салбар, өргөтгөлөөс төвлөрч байгаа
- ТҮЗ-ийн үйлдвэр, салбар, өргөтгөлөөс төвлөрч байгаа
- ТҮЗ-ийн үйлдвэр, салбар, өргөтгөлөөс төвлөрч байгаа

**15-17**      **Финтек ба регтек**



**18-25**      **Судлаачийн индэр**

**26-27**      **Санхүүгээ удирдахад гаргадаг түгээмэл 5 алдаа**




**28-29**      **Олон улсын зах зээлийн мэдээ**



**Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс**

**30**



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### Алдагдсан боломжийн өртөг

#### Opportunity cost

Нөөцийн хомсдолоос шалтгаалан нэг хувилбарыг сонгоход цаана нь сонгох боломжгүйд хүрсэн хамгийн сайн (хоёр дахь сайн) хувилбарын үнэ цэнээр хэмжинэ.



### Байгалийн баялаг

#### Natural resources, land

Бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд ашиглаж болох "байгалийн хишиг". Тухайлбал, далай, агаар, ашигт малтмал, ой мод, газрын баялаг гэх мэт. Газар, эсхүл бусад байгалийн баялагт хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд эдгээр нөөцийн зарим хэсэг нь капиталын нөөц болно. Байгалийн баялгийг газар гэх нь ч бий

Эх сурвалж: Эдийн засаг,  
санхүүгийн нэр томъёоны  
тайлбар толь

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХАД ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Дэлхийн нийтийн уур амьсгалын өөрчлөлт бидний ирээдүйд ихээр нөлөөлөхөөс гадна иргэд, аж ахуйн нэгжүүд уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэж буй олон асуудлуудтай тулгарч байгаа тул уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан болон үр дагаврын талаарх ойлголтыг олон нийтэд таниулах нь чухал асуудал юм. Тогтвортой хөгжлийн зорилтын 13 дугаар зүйл "Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах"-д хадгаламж, зээлийн хоршоод үйл ажиллагаагаараа дамжуулан нөлөөлөх боломжтой тул Азийн хадгаламж, зээлийн хоршоодын холбооноос хадгаламж, зээлийн хоршоод нэн даруй хэрэгжүүлж болохуйц дараах зөвлөмж, аргачлалыг оруулсан. Үүнд:

1. Зээлийн 6 "С"-д "Уур амьсгалын нийцэл"-ийн үзүүлэлтүүдийг оруулах; Эрчим хүч/Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг багасгах үйл ажиллагааны хяналтаар гишүүдэд байгаль орчноо хамгаалах зуршлыг бий болгох, өөрсдөөсөө эхлүүлэн хийж болох энгийн журам бөгөөд гишүүн зээлийн хүсэлт тавих үед "Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад нийцсэн байдал"-ыг үнэлэх арга хэрэгслээр ашиглах;
2. Хадгаламж, зээлийн хоршооны хог хаягдлын хяналт, үнэлгээгээр хог хаягдлын менежментийн хариуцлагыг нэмэгдүүлэх;
3. Бизнес дэх хог хаягдлын менежментийн хяналтыг гишүүдийн зээлийн үнэлгээнд ашиглах;
4. Зээлийн ангилалд ногоон санхүүжилт болон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад нөлөөлөх ангиллыг нэвтрүүлэх;
5. Хадгаламж, зээлийн хоршоодын бизнесийн шийдэл (бодлого, бизнесийн зөв дадал, сургалт)-д Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааг нэгтгэх.

Эмзэг бүс нутгийн хөгжлийг дэмжих нь Тогтвортой хөгжлийн зорилт 13-аас гадна бусад тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмэр оруулна. Эдгээр үйл ажиллагаанууд гамшгийн эрсдэлийн үнэлгээ, байгалийн нөөцийн тогтвортой менежмент болон хүний аюулгүй байдлыг үндэсний хөгжлийн стратегид тусгахыг зорьсон. Зохицуулалттай бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, одоо байгаа технологийг ашиглан дэлхийн дундаж температурын өсөлтийг аж үйлдвэрээс өмнөх үеийнхээс цельсийн 2 хэмээр хязгаарлаж, 1.5 хэмд хүргэх боломжтой хэвээр байгаа ч уг зорилгод хүрэхэд хүн бүрийн хүчин чармайлт, нэгдсэн хамтын ажиллагаа чухал байна. Хадгаламж, зээлийн хоршооны, хувь хүн буюу гишүүний, амьдарч буй орчны түвшинд дараах арга хэмжээг авах боломжтой байна:

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНД	ӨРХ ГЭРИЙН НӨХЦӨЛД	АМЬДАРЧ БҮЙ ОРЧИНДОО
1. Байгаль хамгаалагчдыг томилох	14. Ахуйн хэрэгцээг нарны эрчим хүчний хураагуураар хангах	29. Зам дагуу мод тарих
2. Хуванцар болон хөөсөнцрийн хэрэглээг тэг болох	15. Ахуйн эрчим хүчний хяналт хийдэг төхөөрөмж авах	30. Цэцэрлэгт хүрээлэн байгуулах
3. Хог хаягдлын хяналт хийх	16. LED гэрэлтэй чийдэн сонгох	31. Жижиг хэмжээний цэцэрлэгт хүрээлэн үүсгэх
4. Нүүрстөрөгчийн хийн ялгаралтад хяналт хийх, ялгаралтыг бууруулах	17. Агааржуулагчаа 3 сар тутамд солих эсвэл цэвэрлэх	32. Дээвэр, хучилтаа цайвар өнгөөр хийх
5. Цагаан хоолны дэглэмд шилжих	18. Хуучин тавилгаа шинэчлэн ашиглах	33. Хуучин барилгуудыг хадгалах
6. Байгальд ээлтэй бэлэг дурсгалын зүйлс ашиглах	19. Хувцас дахин боловсруулах	34. Орон нутгийн гол мөрний дагуу цэвэрлэгээ хийх
7. Эрчим хүчээ ногоон болгох	20. Energy star шошготой шинэ цахилгаан хэрэгсэл худалдаж авах	35. Мод үржүүлэх
8. Байгальд ээлтэй оффисын хангамж худалдаж авах	21. Хэрэглээгүй үедээ цахилгаан хэрэгслүүдээ салгах	36. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулахын төлөө хамтдаа нэгдэх
9. Гишүүддээ зориулан байгаль орчин хамгаалах семинар зохион байгуулах	22. Ажлын байраа байгалийн гэрэлд нийцүүлэн төлөвлөх	37. Залуучуудын оролцоог нэмэгдүүлэх
10. Ногоон санхүүжилт	23. Уур амьсгалын хувьд тогтвортой дэлхийн төлөө хооллох	
11. Фермерийн зах зохион байгуулах	24. Хуурайшилтын улиралд тэсвэртэй цэцэрлэгжүүлэлт, ургамлын чимэглэлийг ашиглах	
12. Эрүүл хоол хийх сургалт зохион байгуулах	25. Дахин боловсруулах	
13. Зээлийн үнэлгээнд 6 “С” – Уур амьсгалын нөлөөллийн талаар оруулах	26. Ялзмаг хийх	
	27. Хуванцар савлагаатай уснаас татгалзах	
	28. Хүнсний хаягдлыг багасгах	

### ЭРЧИМ ХҮЧ ЗАРЦУУЛАЛТАА ХЯНАХ СОРИЛ

0 – ХЭЗЭЭ Ч ҮГҮЙ, 1 – ЗАРИМДАА, 2 – ИХЭНХДЭЭ, 3 – ҮРГЭЛЖ	0	1	2	3
<b>Цахилгаан хэрэгсэл, төхөөрөмж</b>				
Хэвийн ажиллагаатай ч эрчим хүч их зарцуулдаг, хуучин цахилгаан хэрэгслүүдийг хаядаг				
Би өөрийн хэрэгцээнд нийцэхгүй том цахилгаан хэрэгсэл худалдаж авдаггүй				
Халаагчийг тогтмол хэмд тохируулах. Агааржуулагчаа 22–24 хэмийн хооронд тохируулдаг				
Дулаан ялгаруулдаг төхөөрөмжүүдийг унтраадаг: Би зурагт, компьютер, принтер, булангийн гэрэл, шарах шүүгээ хэрэглээгүй үедээ унтраадаг				
Агааржуулалтын системээ тогтмол цэвэрлэх нь цахилгаан хэмнэдэг, би агааржуулагчаа тогтмол цэвэрлэж засварлаж, шаардлагатай тохиолдолд шинэ эд ангиар сольдог				
Агааржуулагчаа шөнийн цагаар болон унтаж байх үедээ унтраадаг. Би өдөр агааржуулагчаа асааж, шөнө унтраадаг				
Тоос шороо төхөөрөмжийн эдэлгээг багасгадаг тул би гэрлийн чийдэн, агаар чийгшүүлэгч зэргийг тогтмол цэвэрлэдэг				
Би цахилгаан төхөөрөмжүүдээ хэрэглээгүй үедээ байнга унтраадаг				
Би хөргөгчийн хэмийг 3 хэмээс 5 хэм хүртэл тохируулсан. Хөлдөөгчийг –15°С–аас –18°С–ийн хооронд тохируулдаг				
Би хөргөгч эсвэл хөлдөөгчөө нарны шууд тусгалаас хол сэрүүн газарт шарах шүүгээ, халаагч, аяга таваг угаагчаас хол байршуулдаг				
Би хаалганы дулаалга завсрыг цэвэрхэн, элэгдээгүй байгаа эсэхийг шалгадаг				
Би хөргөгч эсвэл хөлдөөгчийн арын хэсэг болон хананы хооронд хангалттай зай үлдээсэн эсэхийг шалгадаг. Энэ хэсгээр төхөөрөмжөөс ялгарсан дулаан агаар нэвтрэх шаардлагатай				
Би хөргөгчийн арын төмөр торыг цэвэрхэн, тоос шороо, бохирдолгүй байлгаж төхөөрөмжийн үйл ажиллагааг хэвийн байлгадаг				
Би хөргөгч, хөлдөөгчийг хэт ачаалуулахаас зайлсхийдэг				
Би хөргөгчөө тогтмол гэсгээдэг. Мөс таван миллиметрээс илүү зузаантай үед гэсгээдэг.				
Би халуун зүйлийг хөргөгчид хийхээсээ өмнө хөргөнө.				
Би үйлдвэрийн зааврын дагуу цахилгаан хэрэгслүүдээ тогтмол засвар үйлчилгээ хийлгэдэг				
Би Energy star шошготой цахилгаан хэрэгсэл худалдаж авдаг				

<b>Гал тогоонд</b>				
Бид аль болох хамтдаа хооллохыг хичээдэг. Хоолоо төлөвлөх нь эрчим хүчийг хэрхэн бууруулах вэ? Хэрэв хамтдаа хооллож байвал хоолоо халаах шаардлагагүй болно				
Би хоол хийхэд их энерги зарцуулдаггүй энгийн, эрүүл хоол бэлтгэдэг				
Би удаан хугацаа шаардагддаг хоол хийхдээ битүү чанагч хэрэглэдэг				
Ус буцалцагч хэрэглэхдээ усаа зохих хэмжээгээр буцалгана, илүү буцалгасан усаа халуун саванд хадгалдаг				
Би өндөг буцалгахдаа ус буцалсны дараа галыг унтраагаад, галын элчинд өндгөө чанаж дуусгадаг				
Би хөлдөөсөн хүнсээр хийхдээ төлөвлөж хийдэг				
Би хоол хийх явцдаа тогооны тагийг байнга таглаж тавьдаг				
Би хоол хийхдээ түлээ модыг орлуулах нарны эрчим хүч зарцуулдаг зуух ашиглах талаар судалж байна				
<b>Гэр болон ажлын орчин тойронд</b>				
Сүүдэрлэгч ашиглаж нарны гэрлийг халхлах. Сүүдэрлэхийн тулд би наалт, хөшиг, саравч зэргийг ашигладаг. Нар луу харсан цонхны хувьд хөшиг, хөшигний цайвар өнгийн дэвсгэр нарны дулааныг багасгахад тусална.				
Би ямар ч шүршигч, шавж устгал ашиглахгүйгээр цэцэрлэгтээ ногоогоо тарьдаг				
Гэрийн хажуудах жижиг хүнсний дэлгүүрээс нэг удаагийн шампунь, саван, шүдний оо гэх мэт жижиг зүйл худалдаж авахаас зайлсхийдэг				
Би өрөөнд байхгүй үедээ тухайн өрөөнийгөө гэрлийг унтраадаг				
Би 2 минут шүршүүрт ордог				
Би шүдээ угааж, сахлаа хусаж, нүүрээ угааж байхдаа усны цоргыг хаадаг				
Би борооны усыг хураах энгийн төхөөрөмж суурилуулдаг				
Би хувцсаа хатаах олс эсвэл хатаах тавиур дээр хатаадаг				
Мод, усан үзмийн мод, бут сөөг манай гэрт сүүдэр үүсгэдэг				
Би гэрийнхээ хананд цайвар өнгийг ашигладаг				
Би гэртээ салхи/ба/эсвэл нарны эрчим хүчийг ашигладаг				
Би хуучин цахилгаан хэрэгслээ дахин боловсруулдаг/хандивладаг				
Би долоо хоног тутамд нэг удаа угаалга хийдэг				
Би долоо хоногт нэг удаа хувцсаа индүүддэг				
Би өөртөө болон гэр бүлдээ зориулж арчилгаа багатай хувцсыг сонгодог				
Би хувцсаа угаагаад үрчлээсгүй болгон эвхдэг				
Би цэнэглэгчээ ханын залгуураас байнга салгадаг				
Би Energy star шошготой шинэ цахилгаан хэрэгсэл худалдаж авдаг				
Би ажиллах орчноо аль болох байгалийн гэрэл дагуулж тохижуулсан				
Би хэт халуунд тэсвэртэй тохижилт болон ургамлын чимэглэлийг ашигладаг				
Би өөрөө хүнсний ногоогоо тарьдаг				
Би ялзмаг хийдэг				
Би худгийн цэвэр усаар ургамлыг усалдаггүй. Харин гал тогооны усыг дахин ашиглан ургамлаа усалдаг				
<b>Гэрийн гаднах орчинд</b>				
Би нэг удаагийн савласан уснаас зайлсхийн дахин дүүргэж болох усны сав хэрэглэдэг				
Би дэлгүүр явахдаа өөрийн тороо авч явдаг				
Би загас, болон бусад төрлийн махыг хуванцар саванд хийхгүйн тулд өөрийн саваа авчирдаг				
Би гадуур явахдаа хогоо хогийн саванд хаядаг				
Би хогоо, тэр дундаа унасан навчийг шатаалгүй ялзмагийн нүхэнд хийдэг				
Би газар тариалангийн хөрсөө цэвэрлэж, бэлтгэхийн тулд талбай дээр юм шатаадаггүй				
Би нийтийн тээврээр зорчдог				
Манай гэр бүлд хангалттай зайтай нэг л машин бий				
Би нэг давхар доошоо эсвэл дээш гарахдаа лифтээр явахын оронд шатаар явдаг				
Би эрчим хүчээ хэмнэхийн тулд долоо хоногт нэг л удаа зах руу явдаг. Тээврийн хэрэгслээр явахын оронд алхдаг				
Би гадуур хоол идэхдээ хуванцар халбага, сэрээ, савх зэргийг хэрэглэдэггүй				

**Онооны систем:**

144<	Маш сайн
108 – 143	Хангалттай
90 – 107	Боломжийн
90-с доош	Тааруу

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### УИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2025 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦЛЭЭ



Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ. Тайланг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга Н.Хүдэрчулуун танилцуулж, хороо нь өнөөдрийн байдлаар 11 салбарын 5,930 зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд зохицуулалт, хяналт тавин ажиллаж байгааг онцлов.

Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн зах зээлийн уялдаа холбоо, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн орчны шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, даатгал, бичил санхүү болон хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх, санхүүгийн хэрэгслийг төрөлжүүлэхэд анхаарч байна. Мөн санхүүгийн технологид суурилсан инновацыг дэмжих, их өгөгдөлд тулгуурласан хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, ногоон санхүүжилт, хариуцлагатай хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх, салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлээр бодлого хэрэгжүүлж буй.

Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн зах зээлийн олон талт бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээл хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх зорилгоор эрх зүйн орчны шинэчлэлийг шат дараатай хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд даатгалын хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, урт хугацааны даатгалыг хөгжүүлэх, бичил санхүүгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн өргөжүүлэх, хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулж, хөрөнгө оруулагчид чиглэсэн санхүүгийн хэрэгслийг төрөлжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Мөн санхүүгийн

технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих, их өгөгдөлд суурилсан хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, ногоон санхүүжилт болон хариуцлагатай хөрөнгө оруулалтыг дэмжих, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, гадаад, дотоод эрсдэлийн үед салбарын тогтвортой байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд даатгалын багц хуулийг боловсруулж, бичил санхүүгийн салбарын эрх зүйн орчныг Факторингийн тухай, Санхүүгийн түрээсийн тухай, Хамтын санхүүжилтийн үйлчилгээний тухай хуулиудаар боловсронгуй болгох, мөн хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын сангийн тухай (REIT), Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа талаар танилцууллаа.

Танилцуулгын дараа УИХ-ын гишүүн Г.Лувсанжамц хөрөнгийн зах зээлийн сүүлийн жилүүдийн өсөлт болон эрх зүйн шинэчлэлийн сайжруулах хүрээнд хийсэн ажлыг сайшаагаад цаашид ч анхаарч ажиллахыг онцлов. Харин УИХ-ын гишүүн О.Батнайрамдал Засгийн газрын “Чөлөөлье” санаачилга болон эдийн засгийн эрх чөлөөний дөрвөн чөлөөлөлтийн бодлогыг санхүүгийн салбарт хэрэгжүүлэхийг, УИХ-ын гишүүн Л.Соронзонболд банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн хүүг бууруулах чиглэлд бодлогын дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатайг онцолсон юм.

### САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТ ОРОН НУТАГТ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжихэд иргэдийн санхүүгийн мэдлэг боловсрол, оролцоо чухал үүрэгтэй. Ийм учраас

Санхүүгийн зохицуулах хороо иргэд, олон нийтэд санхүүгийн боловсрол олгох, мэдлэг түгээх сургалт хэлэлцүүлгийг тогтмол зохион байгуулсаар байна. Энэ хүрээнд “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран “Хөрөнгийн зах зээл ба 1072 хувьцаа” үнэт цаасны зах зээлийн нээлттэй өдөрлөгийг Говьсүмбэр, Дорноговь аймагт зохион байгууллаа.

Олон нийтийн санхүүгийн боловсрол тэр дундаа хөрөнгийн зах зээлийн үндсэн ойлголт, санхүүгийн эрсдэлээс хэрхэн хамгаалах талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой уг өдөрлөг энэ сарын 24-ний өдөр Замын-Үүд суманд болно. Мөн цаашид бусад аймагт үргэлжлэн зохион байгуулж, иргэдийг санхүүгийн зах зээлд идэвхтэй, мэдлэгтэй оролцогч болгоход туслах зорилготой юм.

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС СОЛИЛЦОО



БНСУ-ын Санхүүгийн хяналт, шалгалтын байгууллага (Financial Supervisory Service)-аас хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх, санхүүгийн хяналт, шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор жил бүр зохион байгуулдаг уламжлалт семинар энэ удаа “Хөрөнгийн зах зээлийн ирээдүйн чиг хандлага” сэдвийн хүрээнд БНСУ-ын Сөүл хотноо боллоо. Тус арга хэмжээ нь олон улсын хөрөнгийн зах зээлийн бодлого, зохицуулалт, хөгжлийн чиг хандлагын талаарх оролцогчдын мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх, олон улсын шилдэг туршлага, шинэлэг шийдлийг танилцуулахад чиглэв. Мөн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөв, бодлого, зохицуулалтын шинэчлэлийн талаар нэгдсэн мэдээлэл хүргэж, оролцогч байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ач холбогдолтой байлаа. Семинарт Санхүүгийн зохицуулах хороо болон Өмнөд, Төв, Зүүн Өмнөд Азийн орнуудын зохицуулагч байгууллагуудын төлөөлөл оролцож, виртуал хөрөнгийн зохицуулалтын тогтолцоо, БНСУ-ын крипто зах зээлийн өнөөгийн байдал, хөгжиж буй орнуудын хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал, үнэлгээний чиг хандлага, зах зээлийн ил тод,

шударга байдлыг хангах, шударга бус арилжааг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ зэрэг асуудлыг хэлэлцэв. Түүнчлэн Япон Улсад ESG мэдээллийн ил тод байдлын стандартыг нэвтрүүлж буй туршлага, БНСУ-ын компаниудын үнэ цэний өсөлт, засаглалын шинэчлэл, цаашдын зорилтыг танилцууллаа. Арга хэмжээний үеэр оролцогчид өөрсдийн орны хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, бодлого, зохицуулалтын орчны талаар танилцуулж, харилцан мэдээлэл, туршлага солилцов.

БНСУ-ын Санхүүгийн хяналт, шалгалтын байгууллага нь санхүүгийн салбарын нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд банк, банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаас, хөрөнгө оруулалтын менежмент, даатгалын салбарын үйл ажиллагааны аюулгүй, тогтвортой байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

### ОРОН НУТГИЙН САНХҮҮГИЙН АЖИЛТНУУДАД МЭДЛЭГ, ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Санхүүгийн зохицуулах хороо нь зохицуулалтын салбарын оролцогчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, санхүүгийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд Увс аймгийн сумдын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнүүд, орон нутгийн төсвийн байгууллагын нягтлан бодогчдыг хамруулсан сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үеэр Санхүүгийн зохицуулах хорооны бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ, зохицуулалтын чиг хандлагын талаар танилцуулж, салбарын зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах асуудлуудын талаар дэлгэрэнгүй мэдээлсэн юм.

Түүнчлэн санхүүгийн залилан, цахим гэмт хэргийн эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар оролцогчдод практик мэдлэг олгож, санхүүгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн ойлголтыг нэмэгдүүлэв. Сургалтын төгсгөлд оролцогчдын тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, харилцан санал солилцоноор орон нутгийн санхүүгийн үйл ажиллагааг илүү үр ашигтай,

ил тод хэрэгжүүлэхэд чухал дэмжлэг үзүүлсэн арга хэмжээ боллоо.

## САНХҮҮГИЙН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ДЭМЖИЖ, АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ШИЛЖҮҮЛЭЭ



УИХ-ын чуулганы энэ сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцүүлэхийг гишүүдийн олонх дэмжиж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

Санхүүгийн хоршооны тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа, Б.Заяабал нар өргөн мэдүүлсэн бөгөөд чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн талаар УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяа, Эдийн засгийн байнгын хорооны холбогдох санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Л.Соронзонболд тус тус танилцуулсан юм. Өнөөдрийн байдлаар 172 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаагаас 53.5 хувь буюу 92 ХЗХ орон нутагт, 46.5 хувь буюу 80 ХЗХ нийслэлд байна. Өнгөрсөн оны байдлаар салбарын нийт хөрөнгө 379.0 тэрбум төгрөгт хүрч, нийт гишүүдийн тоо 77,155 хүрсэн нь эдийн засгийн идэвхтэй хүн амын 5.5 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд нэг зээлдэгчийн дундаж зээл 10.3 сая төгрөг, нэг хадгаламж эзэмшигчийн дундаж хадгаламж 5.3 сая төгрөг байна. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль 2011 онд батлагдсан бөгөөд өнгөрсөн хугацаанд хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулснаас өөрөөр шинэчлэл хийгдээгүй. Уг хуулийн шинэчилсэн найруулга болох Санхүүгийн хоршооны тухай хуулийн төслийг баталснаар тогтворжуулалтын сан, хадгаламжийн даатгал зэрэг хамгаалалтын олон давхарга бүхий салбарын нэгдсэн дэд бүтцийг олон улсын сайн жишгийн дагуу үе шаттай нэвтрүүлэх боломж бодитоор бүрдэнэ. Мөн санхүүгийн олон төрлийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг нээж, ашгийн төлөө бус хуулийн этгээд байх нарийвчилсан зохицуулалтууд хийгдсэнээр санхүүгийн хоршооны зах

зээлийн тогтвортой байдлыг хангах, зах зээлийн цаашдын өсөлтийн нөхцөлийг бүрдүүлэх, гишүүдийн эрх ашгийг хамгаалах механизм боловсронгуй болно. Мөн санхүүгийн хоршоогоор дамжуулан орон нутагт санхүүгийн хүртээмжийг сайжруулах, иргэдэд санхүүгийн боловсрол олгох, гишүүдэд зөв дадал хэвшил суулгах, жижиг, дунд үйлдвэрлэл болон ногоон санхүүжилтийг дэмжих замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, орон нутгийн хөгжлийг дэмжих ач холбогдолтой.

Хууль батлагдсанаар санхүүгийн хоршооны үйл ажиллагаанд тавьж буй хяналт шалгалтын үр нөлөө, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжирч, санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолж, түүнээс сэргийлэх, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах, салбарын хөгжлийг дэмжих таатай орчин бий болно.

## ДААТГАЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ШИНЭЧЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААН БОЛЛОО



УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан “Монгол Улсын даатгалын хууль тогтоомжийн талаар санал, дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн төсөл боловсруулах” чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаан энэ сарын 09-ний өдөр Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд боллоо. Монгол Улсын даатгалын тогтолцоог хүртээмжтэй, өгөөжтэй, тогтвортой, боловсронгуй болгох зорилготой тус ажлын хэсэг нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн даатгалыг үр өгөөжтэй болгох цаашилбал даатгалын салбарыг илүү өрсөлдөөнтэй, санхүүгийн зах зээлтэй уялдсан, иргэдэд бодит үр өгөөжтэй, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход анхаарч ажиллах юм. Түүнчлэн Монгол Улсын нөхцөлд нийцсэн, иргэн төвтэй, ил тод, шударга, эрсдэлд суурилсан шинэ үеийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх хүрээнд олон улсын туршлага, стандартыг судалж, дотоодын онцлогт уялдуулан бодлогын санал, дүгнэлт боловсруулах, шаардлагатай хууль, эрх зүйн өөрчлөлтийг санаачлах чиглэлээр ажиллана.

## ЯРИЛЦЛАГА

### ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН САЛБАРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА



*Санхүүгийн зохицуулах хорооны*

*Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрын дарга Ц.Эрдэнэбаяр*

**Сүүлийн жилүүдэд үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын зах зээлд тодорхой өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Энэ салбарын өнөөгийн зах зээлийн төлөв байдлыг та хэрхэн үнэлж байна вэ?**

Монгол улс 2020 оноос эхлэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч (цаашид “ҮМҮЧЭТХЭАЭ” гэх)–ийн салбарыг төрийн хяналт зохицуулалтад хамруулсан бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 55 хуулийн этгээд, 504 иргэн үйл ажиллагаа явуулж байна.

Салбарт үнэт металлын арилжаа эрхлэгчид, үнэт чулуу, үнэт эдлэлийн бөөний болон жижиглэн худалдаачид, уран дархчууд, үндэсний үйлдвэрлэгчид оролцож олборлолтоос боловсруулалт, үйлдвэрлэл, худалдааг хамарсан уялдаа бүхий зах зээлийн тогтолцоог бүрдүүлж байна.

Монголбанк 2020–2025 онд нийт 118 тонн алт худалдаж авснаас 32.5 хувь буюу 38.4 тонныг үнэт металлын арилжаа эрхлэгчдээс худалдан авсан байна. Гэвч 2023 оноос эхлэн энэ хэмжээ буурсан Тухайлбал Монголбанканд үнэт металл худалдсан иргэдийн тоо 2021 онд давхардсан байдлаар 471 байсан бол 2025 онд 212 болж буурсан нь салбарын идэвхжил буурч байгааг харуулж байна.

Энэ салбарт тодорхой хүндрэл, сорилтууд үүссэнийг илтгэж байна.

**ҮМҮЧЭТХЭАЭ–ийн салбарт ямар гол хүндрэл, сорилтууд тулгарч байна вэ?**

Тус салбар нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртөх эмзэг байдал өндөртэй салбарын нэгт тооцогддог. Үүнтэй холбоотойгоор бэлэн мөнгөний өндөр эргэлт, гүйлгээний ил тод бус байдал, гарал үүслийн тодорхой бус байдал зэрэг эрсдэлийн хүчин зүйлс дагалддаг.

Мөн төрийн байгууллагуудын зохицуулалтад хамаардаг онцлогтой. Энэ нь нэг талаас хяналт, зохицуулалтын хүрээг өргөжүүлдэг боловч нөгөө талаас зохицуулалтын уялдаа сулрах, эрх зүйн зохицуулалтын давхардал эсхүл хийдэл үүсгэх, улмаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг бууруулах эрсдэлийг бий болгож байна.

Иймд төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг бэхжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гарал үүслийн хяналтыг чангатгах, цахимжуулалтыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

**Санхүүгийн зохицуулах хорооноос төрийн бусад байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллаж байна вэ?**

Санхүүгийн зохицуулах хорооноос хэд хэдэн чиглэлд бодлого, зохицуулалтын арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Нэгдүгээрт, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог сайжруулах чиглэлд анхаарч ажиллаж байна. Тухайлбал, 2026 оны 03 дугаар сард Сэлэнгэ, Дархан–Уул, Төв аймагт бичил уурхай эрхлэгч иргэн, хуулийн этгээдэд “Хууль бусаар ашигт малтмал олборлохоос урьдчилан сэргийлэх” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, хууль бус олборлолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

Мөн Монголбанктай хамтран иргэдийн алтны борлуулалтыг нэмэгдүүлэх, мэдээлэл солилцоог сайжруулах чиглэлд ажиллаж байна.

Түүнчлэн гаалийн байгууллагын албан хаагчдад мөнгө угаахтай тэмцэх болон салбарын нөхцөл байдлын талаар мэдээлэл өглөө. Хоёрдугаарт хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхлэгчдийг бүртгэлжүүлэх, үнэт эдлэлийн сорьцын баталгааг тулган баталгаажуулахаар Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж буй худалдааны төвүүдэд 2026 оны 05 дугаар сараас эхлэн газар дээрх хяналт шалгалт хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна.

Гуравдугаарт, салбарт тулгамдаж буй гол асуудал болох эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ажлыг идэвхтэй хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос бие даасан хуулийн төсөл боловсруулах ажлын даалгаврыг баталсан.

### **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ямар бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна вэ?**

Энэ хүрээнд хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Салбарын эрсдэлийн үнэлгээг 2025 онд хоёр дахь удаагаа гүйцэтгэж, цаашид хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний саналыг боловсруулсан.

Мөн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх, технологид суурилсан хяналтын арга хэрэгслийг нэвтрүүлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах, тайлагнал, болон комплаенсын хэрэгжилтийг бэхжүүлэх чиглэлд ажиллаж байна.

Өмнө дурдсанчлан тус салбар өндөр эрсдэлтэйд тооцогддог. ФАТФ-аас 2028–2030 онд Монгол Улсад хийх ээлжит харилцан үнэлгээ хийгдэнэ. Иймд салбарын эрх зүйн орчны шинэчлэл онцгой ач холбогдолтой. Ингэж салбарын эрх зүйн зохицуулалтын цогц, бие даасан байдал бүрдсэнээр энэхүү үнэлгээний үр дүнд шууд нөлөө үзүүлэхээр байна.

Иймд 2026 онд багтаан хуулийн төслийг боловсруулж дуусгахаар төлөвлөж байна.

### **Салбарын ил тод байдлыг сайжруулахад хувийн хэвшлийн оролцоо, чиг үүрэг, хариуцлагыг хэрхэн тодорхойлж байгаа вэ?**

Олон улсын туршлагаас харахад салбарт ил тод байдлыг хангах, эрсдэлийг бууруулахад хувийн хэвшлийн оролцоо маш чухал

үүрэгтэй. Учир нь нийлүүлэлтийн сүлжээ өргөн, олон оролцогчтой тул зөвхөн төрийн хяналтаар бүрэн зохицуулах боломж хязгаарлагдмал юм.

Иймд салбарын салбарын оролцогчид харилцагчийг таньж мэдэх, гүйлгээний хяналт, сэжигтэй гүйлгээний мэдээлэх зэрэг дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай. Энэ нь зөвхөн хууль сахиу төдийгүй бизнесийн нэр хүнд, зах зээлийн итгэлийг хамгаалах ач холбогдолтой.

Мөн жишгээр мэргэжлийн холбоод, олон улсын стандартын хэрэгжилт чухал үүрэгтэй. Тухайлбал, London Bullion Market Association зэрэг байгууллагууд “responsible sourcing” буюу хариуцлагатай нийлүүлэлтийн стандарт, ёс зүйн кодыг мөрдүүлж, гишүүн байгууллагууддаа хатуу шаардлага тавьж байна.

Сүүлийн жилүүдэд дижитал бүртгэл, гүйлгээний хяналтын систем, блокчэйнд суурилсан гарал үүслийн баталгаажуулалтын технологиудыг хувийн хэвшил идэвхтэй нэвтрүүлж байна.

### **Цаашид салбарын чиг хандлагыг хэрхэн харж байна вэ?**

Монгол Улс нь үнэт металлын нөөц ихтэй, уул уурхайн салбар нь эдийн засгийн тэргүүлэх чиглэл тул энэ салбарыг хөгжүүлэх нь стратегийн ач холбогдолтой.

Мөн дотоодын үнэт эдлэлийн үйлдвэрлэл, худалдааг хөгжүүлэх нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгох, ажлын байр нэмэгдүүлэх, жижиг дунд бизнесийг дэмжих чухал боломжийг бүрдүүлнэ.

Дэлхий нийтийн чиг хандлагын хувьд цахим худалдаа, дижитал технологийн хэрэглээ эрчимтэй нэмэгдэж байна. Мөн гарал үүслийн ил тод байдал, хариуцлагатай эх үүсвэрийн хэрэглээ чухал болж, хэрэглэгч төвтэй зах зээл хөгжиж, захиалгат бүтээгдэхүүний эрэлт өсөж байна.


Түүнчлэн үнэт металлыг хөрөнгө оруулалтын хэрэгсэл болгон ашиглах, алт, үнэт металлын сан, бонд, дериватив зах зээлийг хөгжүүлэх хандлага нэмэгдэж байна. цаашид салбарын хөгжлийг тогтвортой, үр ашигтайгаар урагшлуулахын тулд ил тод, хариуцлагатай, технологид суурилсан, олон улсын жишигт нийцсэн зах зээлийн орчныг бүрдүүлэх нь чухал. Ингэснээр салбарын өрсөлдөх чадвар нэмэгдэж, эдийн засагт оруулах хувь нэмэр бодитоор өсөхөөс гадна хөрөнгө оруулагчдын итгэл бэхжих суурь нөхцөл бүрдэх болно.

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## ТОГТВОРТОЙ БОНДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЭЛ

Дэлхийн Банкны Санхүүгийн Тогтвортой Хөтөлбөрийн хүрээнд тогтвортой бондын зах зээлийн чиг хандлага тайланг 2025 оны байдлаар хүргэж байна. Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд тогтвортой өсөлттэй байсан бондын зах зээлийн нийт гаргалтын хэмжээ 2025 онд буурч, бүх ангилалд бууралтын чиг хандлага ажиглагдсан. Тогтвортой бондын зах зээлийн голлох бүтээгдэхүүн болох ногоон бонд, нийгмийн бонд, тогтвортой байдлын бонд, тогтвортой байдалтай уялдсан бонд, шилжилтийн бондын нийт гаргалт 904 тэрбум ам.долларт хүрч, 2024 оны түвшинтэй харьцуулахад 17 хувиар буурсан. 2025 оны 12 дугаар сарын байдлаар зах зээлд гаргасан ногоон бонд, нийгмийн бонд, тогтвортой байдлын бонд, тогтвортой байдалтай уялдсан бонд болон шилжилтийн бондын нийт хуримтлагдсан хэмжээ 6.81 их наяд ам.долларт хүрсэн байна. 2025 оны 4 дүгээр улиралд тогтвортой бондын нийт хэмжээ буурсан ба энэ нь 2019 оноос хойших хамгийн бага түвшинд хүрчээ.

Зураг. Тогтвортой бондын гаргалт 2016–2025 /тэрбум ам.доллар/




Ногоон бонд нь 2025 онд нийт гаргалтын 62 хувийг эзэлж, зах зээл дэх тэргүүлэх хэрэгсэл хэвээр байна. Хэдийгээр гаргалтын орчин хүндрэлтэй хэвээр байх төлөвтэй боловч шинжээчид зах зээлийн уян хатан, тогтвортой шинжийг онцолж, 2026 оны гаргалтын хэмжээ өмнөх оны түвшинд хадгалагдана гэж үзэж байна.

Source: World Bank based on Environmental Finance Data


Тайлант жилд тогтвортой бондын нийт гаргалт хөгжиж буй улс орнуудын (EM) эзлэх хувь нийт бонд гаргалтын 14 хувийг бүрдүүллээ. Ногоон бондын гаргалт нь хөгжиж буй улс орнуудын зах зээл болон хөгжингүй зах зээлүүдэд (AM) хоёуланд нь давамгайл байж, хуримтлагдсан нийт гаргалтын 67 хувь болон 66 хувийг тус тус эзэллээ. Хөгжиж буй тусгаар улс, тэдний төрийн агентлагууд, хотын захиргаа, орон нутгийн болон бүс нутгийн засаг захиргааг багтаасан төрийн секторын оролцоо нийт гаргалтын 26 хувийг эзэлж байгаа бол хөгжингүй орнуудын (AM) бондын зах зээлд энэ үзүүлэлт 42 хувьтай байна.

Зураг. Зах зээл болон бондын төрлөөр ангилсан тогтвортой бондын нийт хуримтлагдсан хэмжээ, тэрбум ам.доллар



Source: World Bank based on Environmental Finance Data

Зураг. Зах зээл болон бонд гаргагчийн төрлөөр ангилсан тогтвортой бондын хуримтлагдсан гаргалтын хэмжээ, тэрбум ам.доллар




Source: World Bank based on Environmental Finance Data

2025 оны 4 дүгээр улирлын гүйцэтгэл:

2025 оны 4 дүгээр улиралд нийт 150.8 тэрбум ам.долларын бонд гарсан нь 2024 оны 4 дүгээр улирал болон 2025 оны 3 дугаар улиралтай харьцуулахад 27.7 хувь болон 33.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2025 оны 4 дүгээр улиралд бондын бүх төрлүүдийн гүйцэтгэл хүлээлтээс доогуур гарч, ногоон бонд, нийгмийн бонд, тогтвортой байдлын бонд, тогтвортой байдалтай уялдсан бонд болон шилжилтийн бондын гаралт 2024 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад 23.4 хувь, 39.0 хувь, 24.5 хувь, 60.9 хувь болон 26.2 хувиар тус тус буурсан байна. Түүнчлэн хөгжингүй улс орнууд (AM) болон хөгжиж буй улс орнууд (EM) дахь бондын гаргалт мөн адил буурч, 2024 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад хөгжингүй улс орнуудад (AM) 20.9 хувь, хөгжиж буй улс орнууд (EM) 41.0 хувиар тус тус буурсан.

Зураг. Бонд гаргагчийн төрлөөр ангилсан тогтвортой бондын улирлын гаргалт, тэрбум ам.доллар




Source: World Bank based on Environmental Finance Data

2025 оны 12 дугаар сарын байдлаар хөгжиж буй орнууд дундаас Чили улс хамгийн өндөр дүнтэй бонд гаргасан улс бөгөөд нийт 56 тэрбум ам.долларын ногоон, нийгмийн, тогтвортой байдлын, тогтвортой байдалтай уялдсан бондууд гаргажээ.

Харин түүний араас Мексик улс 29 тэрбум ам.доллар, Тайланд улс 23 тэрбум ам.долларын бонд гаргасан үзүүлэлтээр удаалж байна.


Зураг. Хөгжиж буй орнуудын гаргасан тогтвортой бондын нийт хэмжээ /тэрбум ам.доллар/



Source: World Bank based on Environmental Finance Data

Хөгжиж буй улс орнуудын (EM) тогтвортой бондын гаргалт 2025 оны 4 дүгээр улиралд харьцангуй сул хэвээр байж, нийт 6.1 тэрбум ам.долларт хүрсэн. Энэ нь 2025 оны 3 дугаар улирал болон 2024 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад 47.8 хувь болон 19.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг. Хөгжиж буй улс орнуудын тогтвортой бондын улирлын гаргалт /тэрбум ам.доллар/



Source: World Bank based on Environmental Finance Data

Тогтвортой санхүүгийн мэдээ:

Тогтвортой санхүүгийн бондын зах зээлд шинэлэг бүтээгдэхүүнүүд эрчимтэй нэмэгдэж байна. Тухайлбал, Дэлхийн Банк Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлтэй уялдсан анхны “Үр дүнд суурилсан бонд”-ыг гаргалаа. Энэхүү бонд нь нүүрстөрөгчийн кредитийн борлуулалттай уялдсан купоны механизмыг хэрэгжүүлсэн нь үр дүнд суурилсан санхүүжилтийн шинэ загварыг бий болгож байна. Мөн Америк Хоорондын Хөгжлийн Банк (IDB) Амазоны бүс нутгийг чиглэсэн "Амазониа бонд" гаргаж, нийт 1 тэрбум австрали доллар (671 сая ам.доллар) амжилттай босгосон бөгөөд энэ нь байгаль орчны хамгаалал болон орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих тогтвортой санхүүжилтийн хүрээг өргөжүүлжээ. Үүнтэй зэрэгцэн Нигери улсын Лагос муж анх удаа ногоон бондын зах зээлд нэвтэрч, Чех улс анхны нийгмийн бонд гаргаснаар уламжлалт бондоос бага зардлаар санхүүжилт татан төвлөрүүлсэн нь төсвийн зардлын үр ашгийг нэмэгдүүлсэн байна. Азийн бүсэд Хонконг дижитал ногоон бонд гаргасан хэмжээгээрээ хамгийн өдөр үзүүлэлт гаргасан бөгөөд блокчейн технологи болон өгөгдлийн стандартчилалд суурилсан санхүүгийн инновацыг хөгжүүлж байна.

Эх сурвалж: World Bank Group. (2026). Labeled sustainable bonds: Quarterly market update (Q4 2025). World Bank Group.

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

## ХЯМРАЛЫН ҮЕД ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Сүүлийн жилүүдэд байгууллагад тохиолдож болох хямралын учир шалтгаан олон төрөл болсон байна. Тухайлбал, кибер халдлага, нэр хүндийн асуудал, бэлтгэн нийлүүлэлтийн тасалдал, геополитикийн тогтворгүй байдал, зохицуулагч байгууллагын хяналт шалгалт, шүүхийн маргаан гэх мэт нь богино хугацаанд нөхцөл байдлыг хүндрүүлснээр компанийн үндсэн үйл ажиллагаа доголдох, санхүүгийн хохирол гарах, олон нийтийн итгэлцэлд сэв суух эрсдэлийг дагуулдаг.

Эдгээр эрсдэл гарах үед үйл ажиллагаагаа тогтвортой байлгах нь зөвхөн компанийн гүйцэтгэх удирдлагын шийдвэр гаргалтын хурд, давтамжаас шалтгаалахгүй бөгөөд төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)–ийн оролцооны хэлбэр, ТУЗ –д ямар мэдээллийг хэн, хэзээ, хэрхэн танилцуулах зэрэг суурь зохион байгуулалтын ажлыг шийдвэрлэх шаардлагатай болно.


Deloitte–ийн “Board Practices Quarterly” (2026 оны гуравдугаар сар) судалгаа нь байгууллагуудын хямралтай нүүр тулах үеийн бэлэн байдлыг зөвхөн “төлөвлөгөөтэй эсэх”–ээр нь үнэлэхгүйгээр, харин уг төлөвлөгөөг тогтмол шинэчилдэг эсэх, стресс тест хийдэг эсэх, мөн ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын эрх, үүргийн зааг, ялгааг нарийвчлан тодорхойлсон эсэхийг харьцуулсан байна.

Судалгаанд нээлттэй (public) болон хаалттай (private) компаниудыг оролцуулсан ба уг судалгаагаар хамгийн их давтагдсан хямралын төрлүүд, бэлэн байдлын төлөвлөгөөнд түгээмэл ажиглагдсан сул талууд, түүнчлэн ТУЗ–ийн оролцооны нийтлэг хэв маяг зэргийг дор товч нэгтгэн хүргэв.

(Асуулт бүрийн хариултын тоо (n) өөр тул доорх зураг, үзүүлэлт бүрд тухайн асуултын тоог тусгав).

### Түгээмэл хямралын төрөл

Судалгаанд дурдсанаар нээлттэй компаниудад сүүлийн 3 жилд нэр хүнд, брэндтэй холбоотой асуудал, кибер халдлага ба өгөгдлийн зөрчил, нийлүүлэлтийн тасалдал болон геополитикийн савлагаа зэрэг нь хамгийн түгээмэл тохиолдсон хямрал байв.



Тайлбар: Олон сонголттой асуулт (Public, n=71). Эх сурвалж: Deloitte, Board Practices Quarterly (2026.03).

Харин хувийн компаниудын хувьд зохицуулагч байгууллагын хяналт шалгалт (41%), кибер халдлага/өгөгдлийн зөрчил (35%), томоохон эрх зүйн маргаан (35%) илүү түгээмэл байжээ (Private, n=17).

Хямралыг нэг хэвийн гэж үзэх, төлөвлөгөөг нэг загвараар боловсруулах нь төдийлөн хангалтгүй тул байгууллага бүр үйл ажиллагааны салбар, бүтээгдэхүүн үйлчилгээ, нийлүүлэгч, мэдээллийн систем, олон нийтийн анхаарал гэх мэт өөрийн онцлог нөхцөлөөс хамаарч болзошгүй хямралын төрлийг бодитоор тодорхойлох шаардлагатай аж.

## Бэлэн байдлын сул тал

Судалгаанд оролцсон байгууллагуудын ихэнх нь хямралын төлөвлөгөөтэй гэж хариулсан боловч “төлөвлөгөөтэй эсэх” –ээс илүүтэйгээр төлөвлөгөөгөө хэр давтамжтай шинэчилдэг, стресс тест хийдэг эсэхээр бэлэн байдлын түвшин нь ялгарч байв. Шүүхийн маргаан болон зохицуулагч байгууллагын хяналт шалгалт нь бодитоор тохиолдож л байдаг атал төлөвлөгөөндөө харьцангуй бага тусгадаг хандлага ажиглагджээ. Хямралын үед оролцогч талуудын эрх хэмжээ, үүрэг хариуцлага, мэдээллийн урсгалын дотоод зохион байгуулалт, олон нийттэй хэн, хэрхэн харилцах гэх мэт нь нарийвчлан зохицуулагдаагүй, тодорхой бус тохиолдолд хугацаа алдах, шийдвэр гаргалт удааширнаас эрсдэл илүү нэмэгддэг байна.

Түүнчлэн хямралыг байгууллагын нэг нэгж дангаараа шийдэх боломжгүй. Төлөвлөгөө нь олон нэгж (компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, олон нийттэй харилцах, эрх зүй МТ/кибер, эрсдэл, санхүү, хүний нөөц, комплайнс, дотоод хяналт, аудит гэх мэт) –үүдийн чиг үүргийг нэг зорилго дор зангидаж, хамтын ажиллагааны ажлын зохион байгуулалтыг тодорхойлох шаардлагатай ба байгууллагын зөв дотоод бүтэц, бүрэлдэхүүн нь мэдээллийн зөрүү, буруу ойлголтоос үүсэх эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.

## ТУЗ–ийн оролцоо ба стресс тест

Ихэнх компаниуд ТУЗ–ийнхөө нийтлэг оролцоог тодорхойлсон боловч хамгийн чухал нь “хэн, юуг, хэрхэн шийдвэрлэх вэ” гэдэг нь маш тодорхой байх ёстой. Компанийн ТУЗ, хороодын дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, байгууллагын нэгж, албан тушаалтны үүрэг хариуцлага, мэдээллийн урсгалд оролцох буюу мэдээ, тайлан гаргах хугацаа зэргийг урьдчилан тодорхойлоогүй бол хямралын үед хугацаа алддаг. Иймээс төлөвлөгөөнд тэдгээрийн мэдээллийн урсгалд оролцох үүрэг хариуцлага, тайлагнах хугацаа, үйл явцыг нарийвчлан журамлах нь чухал.

Судалгаанд оролцогчдын 34 хувь нь ТУЗ–ийг стресс тестэд оролцуулах талаар одоогоор хэлэлцээгүй, 25 хувь нь хэлэлцэж байгаа ч ТУЗ оролцдоггүй, харин 19 хувь нь стресс тест огт хийдэггүй гэжээ.



Тайлбар: Нэг сонголттой асуулт (n=53). Эх сурвалж: Deloitte, Board Practices Quarterly (2026.03).

## Судалгаанд тулгуурласан зөвлөмж:

1. Төлөвлөгөөг жил бүр шинэчилж, дор хаяж нэг удаа туршиж үзэх;
2. Хямралын төрлөө стресс тестэд тулгуурлан шинэчлэх (кибер аюулгүй байдал, нэр хүнд, нийлүүлэлтийн асуудал, зохицуулагч байгууллагын хяналт ийн шалгалт, шүүхийн маргаан гэх мэт);
3. Компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээ, чиг үүргийн зааг, ялгааг журамлах (оролцох нөхцөл, хэлбэр, тайлагнах хугацаа гэх мэт);
4. Хямралын эсрэг багийн бүрэлдэхүүнийг бодит нэгжүүдээс бүрдүүлж, гол чиг үүрэг, оролцоог төлөвлөгөөнд тусгах (хууль, харилцаа холбоо, МТ/кибер, санхүү, эрсдэл, хүний нөөц, комплайнс, дотоод хяналт, аудит зэрэг нэгжийн оролцох чиг үүргийг тусгах);
5. Хямралын дараа дүгнэлтийг заавал хийж, авсан сургамжийг төлөвлөгөөндөө тусгах.

Эх сурвалж: Deloitte (Center for Board Effectiveness), Board Practices Quarterly: “Crisis management and the board”, 2026–03–13.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ ТОП 10 ХИЙМЭЛ ОЮУНЫ ХЭРЭГСЭЛ

Хиймэл оюуны (AI) хэрэгслүүд нь орчин үеийн санхүүгийн салбарт зайлшгүй шаардлагатай болж, байгууллагуудад шийдвэр гаргалтыг сайжруулах, эрсдэлийг удирдах, мөн нарийн төвөгтэй үйл ажиллагаанд илүү өндөр үр ашиг бий болгоход тусалж байгаа юм. Бодит цагийн залилан илрүүлэх, тайланг автоматжуулах, дэвшилтэт таамаглал хийх, хэрэглэгчдэд хувьчилсан үйлчилгээ үзүүлэх зэрэг олон чиглэлд AI нь санхүүгийн байгууллагуудын ажиллаж, өрсөлдөх хэв маягийг өөрчилж байна. Зах зээл тасралтгүй хувьсан өөрчлөгдөж, өгөгдлийн хэмжээ нэмэгдэж буй өнөө үед зөв AI шийдлийг нэвтрүүлэх нь байгууллагын тогтвортой байдлыг хангах, хууль журмыг мөрдөхөд улам чухал болж байна. Ийнхүү Финтек сэтгүүл (Fintech Magazine) нь санхүүгийн байгууллагуудын ажлыг хөнгөвчилж буй шилдэг 10 AI хэрэгслийг онцлон танилцуулж байна.



#### 10. ZEST AI



Үүсгэн байгуулагдсан: 2009 он  
Төв байр: АНУ, Бурбанк  
Гүйцэтгэх захирал (CEO): Mike de Vere  
Ажилтны тоо: ~200

Zest AI нь машин сургалтад суурилсан андеррайтинг болон эрсдэлийн шинжилгээгээр дамжуулан санхүүгийн байгууллагуудын зээлийн шийдвэр гаргалтыг сайжруулахад тусалдаг. Тус платформ нь зээлдэгчийн төлбөрийн чадварыг илүү нарийвчлалтай үнэлэх, зээлийн хүртээмжийг өргөжүүлэх, мөн зохицуулалтын шаардлагыг илүү сайн хангах боломжийг олгоно. Нарийн төвөгтэй загварчлал болон батлах үйл явцыг автоматжуулснаар Zest AI нь зээлийн шийдвэрийг илүү хурдан, шударга, ашигтай болгоход дэмжлэг үзүүлж, санхүүгийн салбарын нийт гүйцэтгэлийг сайжруулдаг.

#### 9. QUANTEXA

Үүсгэн байгуулагдсан: 2016 он  
Төв байр: Их Британи, Лондон  
Гүйцэтгэх захирал (CEO): Vishal Marria  
Ажилтны тоо: 650+

Quantexa нь санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлага болон харилцагчийн ойлголтыг сайжруулахад чиглэсэн хиймэл оюунд суурилсан шийдвэрийн интеллект шийдлийг санал болгодог. Тус платформ нь тусгаарлагдсан өгөгдлүүдийг нэгтгэн, нуугдмал холбооснуудыг илрүүлж, сэжигтэй үйл ажиллагааг таних боломжийг бүрдүүлдэг. Санхүүгийн байгууллагууд Quantexa-г ашиглан зохицуулалтын нийцлийг бэхжүүлэх, залилангийн



эрсдэлийг бууруулах, мөн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх боломжтой.

#### 8. ORACLE FUSION CLOUD FINANCIALS

Үүсгэн байгуулагдсан: 1977 он  
Төв байр: АНУ, Остин  
Гүйцэтгэх захирлууд (CEOs): Clay Magouyrk, Mike Sicilia



Ажилтны тоо: ~162,000

Oracle Fusion Cloud Financials нь хиймэл оюун ухаанаар сайжруулсан санхүүгийн менежментийн шийдэл бөгөөд олон улсын томоохон байгууллагуудад илүү өндөр үр ашиг, хяналттай ажиллах боломж олгодог. Тус платформ нь нягтлан бодох бүртгэл, төсөөлөл (forecasting), зардлын удирдлага болон эрсдэлийн шинжилгээ зэрэг үндсэн процессуудыг автоматжуулдаг. Суулгасан аналитик болон бодит цагийн тайлагналын тусламжтайгаар санхүүгийн багууд өгөгдлийн үнэн зөв байдлыг сайжруулж, гар ажиллагааг бууруулахын зэрэгцээ бизнесийн нөхцөл байдалд хурдан хариу үзүүлэх боломжтой болдог. Мөн Oracle-ийн үүлэн технологид суурилсан шийдэл нь өргөжих чадвар, зохицуулалтын нийцэл болон стратегийн шийдвэр гаргалтыг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдагаараа давуу талтай юм.

## 7. FEEDZAI



Үүсгэн байгуулагдсан: 2011 он  
Төв байр: Португал, Лиссабон  
Гүйцэтгэх захирал (CEO): Nuno Sebastiao  
Ажилтны тоо: 500+

Feedzai нь банк, финтек болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан хиймэл оюун ухаанд суурилсан залилан илрүүлэлт болон санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэргэшсэн компани юм. Тус платформ нь гүйлгээг бодит цагийн горимд шинжилж, сэжигтэй хэв маягийг илрүүлэхийн зэрэгцээ буруу эерэг дохиоллыг бууруулахад тусалдаг. Машин сургалт болон зан төлөвийн шинжилгээг хослуулснаар Feedzai нь байгууллагуудад хэрэглэгчээ хамгаалах, зохицуулалтын шаардлагыг хангах, мөн дижитал төлбөрийн тасралтгүй, найдвартай орчныг бүрдүүлэх боломж олгодог.

## 6. IBM WATSONX ORCHESTRATE



Үүсгэн байгуулагдсан: 1911 он  
Төв байр: АНУ, Нью-Йорк  
Гүйцэтгэх захирал (CEO): Arvind Krishna  
Ажилтны тоо: ~300,000

IBM watsonx Orchestrate нь хиймэл оюун ухааныг ашиглан ажлын урсгалыг автоматжуулж, санхүүгийн үйл

ажиллагааны бизнес процессуудыг илүү үр ашигтай, хялбар болгодог бөгөөд тус шийдэл нь тайлан гаргах, зөвшөөрөл авах, өгөгдөл удирдах зэрэг давтагддаг ажлуудыг илүү хурдан, үр дүнтэй гүйцэтгэх боломжийг олгодог. Өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагаанд AI туслахуудыг нэгтгэснээр байгууллагууд бүтээмжийг нэмэгдүүлж, шийдвэр гаргалтын хурдыг сайжруулахын зэрэгцээ үйл ажиллагааны төвөгшлийг бууруулж, байгууллагын хэмжээнд аюулгүй автоматжуулалтыг дэмжих боломжтой.

## 5. UPSTART FOR LENDERS



Үүсгэн байгуулагдсан: 2012 он  
Төв байр: АНУ, Сан Матео  
Гүйцэтгэх захирал (CEO): Dave Girouard  
Ажилтны тоо: ~1,200

Upstart нь уламжлалт зээлийн онооны загвараас давсан зээлдэгчийн үнэлгээг сайжруулах замаар зээлийн салбарыг орчин үеийн болгоход хиймэл оюун ухааныг ашигладаг бөгөөд тус платформ нь банк болон зээлийн холбоодод зээл олголтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрсдэлийн түвшнийг бууруулахад дэмжлэг үзүүлдэг. Мөн алтернатив өгөгдөл болон автомат шийдвэр гаргалтыг ашигласнаар Upstart нь санхүүгийн үйлчилгээг илүү хүртээмжтэй болгож, хэрэглэгчийн туршлагыг сайжруулахын зэрэгцээ хувь хүн болон жижиг бизнесийн зээлийн үйл явцын үр ашгийг нэмэгдүүлдэг.

## 4. ANAPLAN

Үүсгэн байгуулагдсан: 2006 он  
Төв байр: АНУ, Майами  
Гүйцэтгэх захирал (CEO): Charlie Gottdiener  
Ажилтны тоо: 2,000+



Anaplan нь санхүүгийн удирдлагын баг болон байгууллагуудад зориулсан хиймэл оюун ухаанд суурилсан төлөвлөлт, төсөөллийн шийдлүүдийг санал болгодог бөгөөд тус компанийн холбогдсон платформ нь санхүү, үйл ажиллагаа болон стратегийн төлөвлөлтийг нэгтгэн, уян хатан байдал болон хувилбарын загварчлалыг сайжруулдаг. Байгууллагууд Anaplan-ыг ашиглан хэлтэс хоорондын шийдвэр гаргалтыг уялдуулах, нөөцийн хуваарилалтыг оновчлох, мөн бодит цагийн мэдээлэл болон

хамтын төлөвлөлтийн тусламжтайгаар зах зээлийн өөрчлөлтөд илүү хурдан хариу үзүүлэх боломжтой болдог.

### 3. BLACKLINE VERITY AI

Үүсгэн байгуулагдсан: 2001 он

Төв байр: АНУ, Лос Анжелес

Гүйцэтгэх захирал (CEO): Owen Ryan

Ажилтны тоо: ~1,800



BlackLine Verity AI нь дансны тулгалт болон санхүүгийн хаалтын процессуудыг ухаалгаар

автоматжуулж, санхүүгийн багуудад алдаа, зөрчил илрүүлэх, гар ажиллагааг бууруулах, мөн тайлагналын үнэн зөв байдлыг хангахад тусалдаг бөгөөд үндсэн нягтлан бодох бүртгэлийн ажлуудад хиймэл оюун ухааныг ашигласнаар зохицуулалтын нийцлийг бэхжүүлж, ил тод байдлыг нэмэгдүүлэн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, байгууллагуудыг санхүүгийн хаалтыг илүү хурдан гүйцэтгэхийн зэрэгцээ мэдээллийн найдвартай байдлыг хадгалах боломжийг бүрдүүлдэг.

### 2. DATAROBOT



DataRobot

Үүсгэн байгуулагдсан: 2012 он

Төв байр: АНУ, Бостон

Гүйцэтгэх захирал (CEO): Debanjan Saha

Ажилтны тоо: 1,000+

DataRobot нь санхүүгийн байгууллагуудад таамаглалын (predictive) загваруудыг өргөн цар хүрээнд боловсруулах, нэвтрүүлэх болон удирдах боломжийг олгодог байгууллагын түвшний хиймэл оюуны платформ юм. Энэхүү платформ нь банк, даатгал болон хөрөнгийн зах зээлд өргөн хэрэглэгддэг бөгөөд залилан илрүүлэх, зээлийн эрсдэлийн үнэлгээ хийх, зохицуулалтын шаардлагыг хангах, санхүүгийн таамаглал боловсруулах зэрэг хэрэглээнд ашиглагддаг. Автомат машин сургалт (AutoML) болон загварын дэвшилтэт хяналтын боломжуудаар дамжуулан DataRobot нь санхүүгийн багуудад хиймэл оюуны нэвтрүүлэлтийг хурдасгахын зэрэгцээ ил тод байдал, хяналтыг хадгалахад тусалдаг. Тус платформ нь одоо ашиглагдаж буй өгөгдлийн орчинтой уялдан ажиллах боломжтой бөгөөд байгууллагуудад чухал үйл ажиллагааны

процессуудад хиймэл оюуныг аюулгүйгээр нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Хурд, нарийвчлал болон шийдвэр гаргалтын чанарыг сайжруулснаар DataRobot нь илүү ухаалаг санхүүгийн стратеги боловсруулж, бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

### 1. ALPHASENSE

Үүсгэн байгуулагдсан: 2011 он

Төв байр: АНУ, Нью-Йорк

Гүйцэтгэх захирал (CEO): Jack Kokko

Ажилтны тоо: 2,500+

AlphaSense

AlphaSense нь дэлхий даяарх санхүүгийн байгууллагууд,

хөрөнгө оруулалтын компаниуд болон корпорацын санхүүгийн багуудын ашигладаг хиймэл оюун ухаанд суурилсан зах зээлийн судалгааны тэргүүлэгч платформ юм. Тус платформ нь байгалийн хэл боловсруулалтын технологи (NLP) ашиглан орлогын тайлангийн дуудлагын бичлэг, SEC-д гаргасан мэдүүлгүүд, брокерын судалгаа, компанийн тайлангууд болон дэлхийн мэдээ зэрэг асар их хэмжээний өгөгдлийг шинжилдэг. Мөн түүний генератив AI чадвар нь хайлт, хураангуйлалд болон чиг хандлагын илрүүлэлтийг сайжруулж, санхүүгийн удирдагчдад илүү оновчтой хөрөнгө оруулалт болон стратегийн шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлдэг бөгөөд үүний үр дүнд AlphaSense нь чухал мэдээлэлд хандах болон боловсруулах арга барилыг шинэчилж, орчин үеийн санхүүгийн шинжилгээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. AlphaSense нь мэргэжилтнүүдэд мэдээллээс үнэ цэнтэй дүгнэлтийг илүү хурдан гаргах, нарийвчилсан шалгалтыг (due diligence) бэхжүүлэх, мөн хурдтай өөрчлөгдөж буй зах зээлд өрсөлдөх давуу тал олж авах боломжийг бүрдүүлдэг. Тус платформын генератив хиймэл оюун (Gen AI) боломжууд нь хайлт, хураангуйлалд болон тренд илрүүлэлтийг сайжруулж, санхүүгийн удирдлагуудад илүү үндэслэлтэй хөрөнгө оруулалтын болон стратегийн шийдвэр гаргахад тусалдаг. Чухал мэдээллийг хэрхэн олж авах, тайлбарлан ойлгох арга барилыг шинэ түвшинд хүргэснээр AlphaSense нь орчин үеийн санхүүгийн шинжилгээнд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Эх сурвалж: <https://fintechmagazine.com/top10/top-10-ai-tools-for-finance>

# СУДЛААЧИЙН ИНДЭР

## ВАЛЮТ АРИЛЖИХ ТӨВИЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

*Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх болно.*

### Гүйцэтгэсэн:

СЗХ, Зах зээлийн судалгаа хөгжлийн газрын мэргэжилтэн, Б.Гал Gal@frc.mn

### ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар гадаад валют арилжааны олон улсын туршлага, тухайлбал Турк, Танзани, Тайланд, Арабын Нэгдсэн Эмират Улсын эрх зүйн зохицуулалт, хяналтын тогтолцоог харьцуулан судалсан болно. Судалгааны хүрээнд тухайн улсын зохицуулагч байгууллага, тусгай зөвшөөрлийн нөхцөл, хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлага, байршлын шалгуур, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогын хэрэгжилтийг авч үзсэн. Уг харьцуулсан судалгаанд тулгуурлан Монгол Улсад гадаад валют арилжааны зохицуулалтын орчныг олон улсын сайн туршлагад нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор бодлогын зөвлөмжийг дэвшүүлсэн.

### УДИРТГАЛ

Гадаад валютын арилжаа нь дэлхийн санхүүгийн зах зээл дээр өдөр бүр ойролцоогоор 7 их наяд ам.долларын гүйлгээ хийгддэг томоохон салбар бөгөөд (BIS, 2022) улс орны мөнгөний бодлого хэрэгжүүлэх, төлбөр тооцооны тогтвортой байдалд чухал нөлөөтэй.

Гэсэн хэдий ч энэ нь мөнгө угаах болон терроризмын санхүүжилтийн өндөр эрсдэлийг агуулдаг бөгөөд FATF тайланд валют арилжааны төвүүдийг өндөр эрсдэлтэй үйлчилгээний ангилалд багтаадаг. Иймээс улс орнууд энэ чиглэлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр, нарийн зохицуулалт, хяналтын дор эрхлэхийг шаарддаг. Энэхүү судалгаанд гадаад валют арилжаа эрхлэх үйл ажиллагаанд хамаарах олон улсын Турк, Танзани, Тайланд, Арабын Нэгдсэн Эмират Улсын эрх зүйн зохицуулалт, хяналтын тогтолцоог харьцуулсныг судалсан. Судалгаанд дараах асуудлыг авч үзсэн. Үүнд:

- ◆ гадаад валют арилжаа зохицуулалтын байгууллагын бүтэц,
- ◆ тусгай зөвшөөрөл олгох нөхцөл,
- ◆ үйл ажиллагаа явуулах байршлын зохицуулалт (байршилд хязгаарлалт тавьдаг эсэх),
- ◆ хувь нийлүүлсэн хөрөнгийн доод шаардлага,
- ◆ өдөрт арилжаалах дээд хэмжээ,
- ◆ ажлын байр болон хүний нөөцийн шаардлага, стандарт,
- ◆ мөнгө угаах болон терроризмын санхүүжилттэй тэмцэх (AML/CFT) бодлого.

Эдгээр асуудлын хүрээнд олон улсын туршлагыг Монгол Улсад мөрдөгдөж буй зохицуулалтын орчны харьцуулан судалж, сайжруулах боломжит санал, зөвлөмжийг боловсруулан дэвшүүлсэн.

Энэхүү судалгааны ажил нийт таван бүлэгтэй. Эхний бүлэгт валют арилжааны төвийн онцлогийг танилцуулж, хоёрдугаар бүлэгт олон улсын туршлага, гуравдугаар бүлэгт Монгол Улсын эрх зүйн зохицуулалтын тус тус авч үзсэн. Дөрөвдүгээр бүлэгт судлагдсан орнуудын харьцуулсан шинжилгээ хийж, тавдугаар бүлэгт дүгнэлт болон санал зөвлөмжийг тусгалаа.

## ГАДААД ВАЛЮТ АРИЛЖАА

Валют арилжаалах төв (Currency exchange office, bureau de change, money changers, foreign exchange offices) нь ихэвчлэн бага дүнтэй, жижиглэн бэлэн болон бэлэн бусаар арилжаа хийдэг жуулчид, гадаадад ажиллагсад болон жижиг бизнес эрхлэгчдэд үйлчилдэг.

Эдгээр шинж чанаруудаас үүдэн олон улсын байгууллагууд тухайлбал Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага FATF болон MONEYVAL<sup>2</sup>-ын тайланд валют арилжаа эрхлэхийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй үйлчилгээний ангилалд хамруулдаг.

Ийм эрсдэлийг бууруулах зорилгоор олон улсад валют арилжааны байгууллагуудад дараах нийтлэг зохицуулалтын шаардлагуудыг хангаж ажилладаг байна. Үүнд:

### 1. Үндсэн шаардлагууд тавина.

- ◆ Тусгай зөвшөөрөлтэй байх
- ◆ Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх
- ◆ Ажлын байр, тоног төхөөрөмжийн стандартыг хангасан байх

## ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

### Турк Улс

Турк Улсад бага хэмжээний валют арилжааны төвүүдийн Сангийн яам (Ministry of Treasury and Finance)-ны 2018–32/45 тоот тушаалаар зохицуулдаг. Сангийн яам нь валют арилжааны төвүүдийн үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, бүртгэл хөтлөх, хянах, шаардлагатай тохиолдолд зөвшөөрлийг цуцлах эрхтэй. Энэхүү тушаал нь валют арилжааны төвүүдийг А болон В бүлэг гэж ангилж лицензжүүлдэг.

Бүртгэл зөвшөөрөл

- ◆ Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн ил тод хяналтын тогтолцоотой байх
- ◆ Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, тайлагнах мэдээлэх тогтолцоотой байх

### 2. Шаардлага хангасан бол үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллагаас олгоно:

- ◆ Төв банк
- ◆ Сангийн яам
- ◆ Санхүүгийн зохицуулагч байгууллага

### 3. Дараах нийтлэг эрх зүйн зохицуулалтыг мөрдөнө:

- ◆ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх (AML/CFT)
- ◆ Харилцагч таних журам (KYC)
- ◆ Сэжигтэй гүйлгээний мэдэгдэл (STR)
- ◆ Эрсдэлийн үнэлгээ болон дотоод хяналтын бодлого, хөтөлбөр, журам

Үйл ажиллагааны цар хүрээгээр нь ангилж, дараах нэршлийг компанийн нэрд заавал тусгасан байна: А бүлгийн байгууллагууд “Exchange Office”, В бүлгийн байгууллагууд “Limited Exchange Office”

Тусгай зөвшөөрөлтэй эдгээр байгууллагууд нь зөвхөн гадаад валют арилжааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэй ба бусад төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

Мөн компанийн 10 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчид, гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүд болон

<sup>2</sup><https://www.fatf-gafi.org/en/publications/Methodsandtrends/Moneylaunderingthroughmoneyremittanceandcurrencyexchangeproviders.html>

гарын үсэг зурдаг эрх бүхий ажилтнууд нь “тохиромжтой этгээд” байх шалгуурыг хангаж, хууль, зохицуулалтын хүрээнд шаардлагатай ёс зүйн болон санхүүгийн шалгуурыг хангасан байх шаардлагатай.

В бүлэг (Group B) үйл ажиллагааны хүрээ:

- ◆ Гадаад валют худалдах, худалдан авах;
- ◆ Гадаад валютыг өөр хооронд нь солих;
- ◆ Гадаад валютын чек худалдаж авах;
- ◆ 1 кг–аас бага жинтэй, 24 каратын стандарт алт худалдах, худалдан авах.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 1 сая турк лирийн хөрөнгөтэй байх.

А бүлэг (Group A) үйл ажиллагааны хүрээ:

В бүлгийн үйл ажиллагаанд дээр дурдсанаас гадна доор дурдсан үйл ажиллагаа эрхэлнэ.

- ◆ 1 кг–аас дээш жинтэй, 24 каратын стандарт алт худалдах, худалдан авах;

- ◆ Хөрөнгийн биржийн гишүүн байх нөхцөлтэйгөөр үнэт чулууг стандарт болон стандарт бус үнэт металлыг импортлох, экспортлох мөн холбогдох хууль, журмын хүрээнд хөрөнгийн бирж дээр тэдгээртэй холбоотой арилжаа хийх;
- ◆ Цахим мөнгөний байгууллага болон төлбөрийн байгууллагын төлөөлөгчөөр ажиллах;
- ◆ Яамнаас зөвшөөрөл авсан нөхцөлд төв оффис, салбар болон бусад тохиромжтой гэж үзсэн байршилд мөнгөний автомат машин ашиглан гадаад валют худалдаж авах, зарах, холбогдох гүйлгээг хийх;
- ◆ Банкны карт болон урьдчилсан төлбөрт карт ашиглан валют арилжаа хийх;
- ◆ Валютыг гадаадад гаргах (Сангийн яамны зөвшөөрлөөр);
- ◆ Яамнаас зохистой гэж үзсэн бусад үйл ажиллагааг гүйцэтгэх;
- ◆ Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 5 сая турк лирийн хөрөнгөтэй байх.

#### Хүснэгт. Турк Улсын валют арилжих төвд тавигдах шаардлага

Ангилал	Шаардлага
Үйл ажиллагааны нөхцөл	Валютын гүйлгээ нь тусгай касс, дансаар дамжина Яамны зөвшөөрөлгүй нэмэлт шимтгэл авах хориотой
Таних тэмдэг, ил тод байдал	Ажилтнууд болон хэрэглэгчдэд зориулсан “Салбарын зөвшөөрлийн гэрчилгээ”–г ажлын байранд байрлуулах А, В ангиллын таних тэмдэгтэй самбар байх Валютын ханшийг тодорхой харуулсан дэлгэц (доллар, евро) байх
Төхөөрөмж	Хангалттай талбай, тоног төхөөрөмж Төлбөр хүлээн авах төхөөрөмжүүд суурилуулсан байх
Камер хяналт	Камер, дүрс бичлэгийн системтэй байх /6 сар хадгалах/ Гэмтэл гарсан тохиолдолд шууд мэдэгдэнэ
А ангиллын нэмэлт шаардлага	Ерөнхий менежер: магистрын зэрэг, 3+ жилийн туршлага Дотоод хяналтын ажилтан: магистрын зэрэгтэй байх Эрсдэлийн удирдлагын систем, дотоод хяналтын хөтөлбөр байгуулсан байх AML / CFT–д нийцэх хяналтын арга хэмжээ хэрэгжүүлэх Бүртгэл, тайлан, харилцаа холбооны зохион байгуулалт
KYC / гүйлгээний бүртгэл	20,000 TL ~ 510 USD–оос давсан арилжаанд харилцагчийг таньж баталгаажуулах үүрэгтэй.

Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал, хөгжил дэвшлийг харгалзан үзэж шинэ валют арилжааны шинэ байгууллага байгуулах, салбар нээх зөвшөөрөл олгохыг түр зогсоох, хязгаарлах, мөн валют арилжааны төвүүдийг Турк Улсын нутаг дэвсгэр дэх муж, гаалийн боомт, нисэх онгоцны буудалд байгуулах боломжтой байршил болон тоог тогтоох эрхийг Сангийн яам хэрэгжүүлдэг.

## Танзани Улс

Танзани Улсад валют арилжааны төвүүдийг Танзани Улсын Төв банк зохицуулдаг. 2023 оны 10 дугаар сарын 06–ны өдөр "Гадаад Валютын Журам, 2023" (GN No. 730 of 2023) –д нэмэлт өөрчлөлт оруулж баталсан. Уг журамд валют арилжааны төвүүдийн зохицуулалт, хяналтыг шинэчилж Валют арилжааны төвүүдийг А, В, С гэж ангилж үйл ажиллагааны хүрээг тогтоосон.

### Бүртгэл, зөвшөөрөл

Ангилал А: Гадаад эсвэл дотоодын хөрөнгө оруулалттай, спот арилжаа, мөнгөн гуйвуулга болон бусад санхүүгийн үйлчилгээ эрхлэх эрхтэй. Гадаадын хөрөнгө оруулалттай төвүүдэд хамгийн багадаа 1 тэрбум Танзани шиллинг (ойролцоогоор 400,000 ам.доллар), дотоодын хөрөнгө оруулалттай төвүүдэд 500 сая Танзани шиллинг (ойролцоогоор 200,000 ам.доллар) хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

Ангилал В: Дотоодын хөрөнгө оруулалттай зөвхөн спот арилжааг эрхлэх эрхтэй. Хамгийн багадаа 200 сая Танзани шиллинг (ойролцоогоор 80,000 ам.доллар) хөрөнгийн шаардлага хангасан байна.

Ангилал С: Гурван одтой болон түүнээс дээш зэрэглэлтэй зочид буудлуудад байрлах, зөвхөн тухайн зочид буудлын үйлчлүүлэгчдэд зориулсан спот арилжаа эрхлэх эрхтэй. Хөрөнгийн шаардлага тавигдахгүй боловч 1 сая танзани шиллингийн хураамж төлнө.

Валют арилжааны үйл ажиллагаа эрхлэгчид тавигдах шаардлага:

*Хүснэгт. Танзани Улсын валют арилжих төвд тавигдах шаардлага*

Ангилал	Шаардлага
Хуулийн хэлбэр	Танзани Улсад бүртгэлтэй хувьцаат компани эсвэл зочид буудал байна.
Бүрдүүлэх баримт бичиг	Улсын бүртгэлийн гэрчилгээ, хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, банкны хуулга (хөрөнгө батлах), байршлын гэрээ (түрээс эсвэл өмч), камерын суурилуулалтын нотолгоо, AML дотоод журам
Зөвшөөрөл олгох хугацаа	Урьдчилсан зөвшөөрлийг 30 хоногт олгоно. Лицензийг 6 сарын дотор авна.
Ажлын байрны нөхцөл	Хангалттай талбай, камержуулалд, хамгаалалтын систем, холбооны хэрэгсэл, боловсруулалтын төхөөрөмж, нягтлан бодох бүртгэлийн систем бүгд хэвийн ажиллагаатай байна.
Хөрөнгийн нөхцөл KYC / гүйлгээний бүртгэл	Үргэлж хувь нийлүүлсэн хөрөнгийн 70%–тай тэнцэх хэмжээний хөрөнгөтэй байна. 5,000 USD–оос давсан арилжаанд хүчинтэй иргэний үнэмлэх, нотлох бичиг бүртгэж хадгална
Бичиг баримтын ил тод байдал	Валютын ханш, үйлчилгээний хураамж, хүчинтэй лиценз зэрэг мэдээллийг хэрэглэгчдэд нээлттэй, харагдахуйц байдлаар байршуулсан байна.
Байршил	Нийтийн хандалттай, аюулгүй, Төв Банкнаас зөвшөөрсөн байршилд байх ёстой гэж тусгасан байна.  Төв банк байрны үзлэг хийж, тохиромжтой гэж үзсэн тохиолдолд зөвшөөрөл олгоно

Валют арилжааны газар нь ажилтнуудаа өөрийн үйл ажиллагаа болон холбогдох хууль, зохицуулалтын шаардлагын талаар хангалттай сургаж бэлтгэх үүрэгтэй. Валют арилжааны төвүүд нь зөвхөн спот арилжаа эрхлэх эрхтэй бөгөөд ирээдүйн огноотой арилжаа хийхийг хориглоно. Бүх валют арилжааны төвүүд нь үйл ажиллагааны тайлан, мэдээг Төв Банканд тогтмол хүргүүлэх үүрэгтэй.

### **Тайланд Улс**

Тайландын жижиглэнгийн валют арилжааны төвүүд (Authorized Money Changers, AMC) нь гадаад валютыг бэлэн арилжих чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Тайландын Төв Банк (Bank of Thailand, BOT) нь эдгээр төвүүдийн харилцааг зохицуулах, хяналт тавих, мөнгө угаах болон терроризмын санхүүжилтээс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий бодлого хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь валют арилжааны эрхлэгчийн үйл ажиллагааг “Rules and Practices regarding the Undertaking of Authorized Money Changers” журмаар зохицуулагддаг.

Гадаад валют арилжаа эрхлэх хүсэлтээ Тайландын Төв банкаар дамжуулан Сангийн яаманд хүсэлт гаргана. Хүсэлтийг жилд 4 удаа (3, 6, 9, 12-р сард) хүлээж авдаг.

Валют арилжаалах үйлчилгээ эрхлэх боломжтой хуулийн этгээдүүд (ангилал):

1. Гадаад жуулчдад танигдсан зочид буудал;
2. Гадаад жуулчдад зориулсан үйлчилгээ эрхэлдэг байгууллага (аялал жуулчлалын компани, нисэх буудал, том дэлгүүр гэх мэт) 10 сая батаас дээш хөрөнгөтэй байх;
3. Бүх удирдлага нь Тайландын иргэдээс бүрдэх ба компани 1 сая батаас дээш хөрөнгөтэй байх;
4. Албан ёсны татваргүй дэлгүүр;
5. Засгийн газрын байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгж;
6. Хил орчмын аялал жуулчлалын бүсэд байрладаг Тайландын иргэдийн эзэмшдэг хувийн бизнес.

Үндсэн шаардлагууд:

1. Хуулийн этгээд байх (байгууллагын бүртгэлтэй);
2. 10 сая Тайланд батаас багагүй хөрөнгөтэй байх;
3. Бизнесийн байр нь тодорхой байршилд, аюулгүй байдал хангагдсан, камер болон хяналтын системтэй байх;
4. AML/CFT дотоод бодлого, журамтай байх;
5. Тохиромжтой этгээдийн шаардлага хангахуйц удирдлагын бүтэцтэй байх.

Хуульд заасан валют арилжаалах үйлчилгээ эрхлэх боломжтой хуулийн этгээдүүд 1–5 дугаар ангиллын этгээдүүд өдөрт нэг хүнд 800,000 бат, хил орчмын бүсэд үйл ажиллагаа явуулдаг хувийн бизнесүүдийн хувьд энэ дүн 200,000 бат–аар хязгаарлагдана. Мөн 50,000 бат ба түүнээс дээш гүйлгээнд харилцагчийг таньж бүртгэл хөтөлнө.

### **Арабын Нэгдсэн Эмират Улс**

Арабын Нэгдсэн Эмират Улсын (АНЭУ) гадаад валют арилжааны тогтолцоо нь Төв банк (CBUAE)–ны зохицуулалтад байдаг бөгөөд валют арилжаа эрхлэх үйл ажиллагааг “Regulations Re Licensing and Monitoring of Exchange Business” журмаар

зохицуулж, хяналт тавьдаг. АНЭУ–д гадаад валют арилжаа эрхлэгч нь Төв банкнаас олгосон тусгай зөвшөөрөл байна.

Гадаад валют арилжаа эрхлэгчид нь дараах нөхцөлүүдийг хангасан байна. Үүнд:

- ◆ Гадаад валютын арилжаа болон аяллын чек худалдах үйл ажиллагаанд 2 сая дирхам, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаанд 5 сая дирхам, цалингийн төлбөрийн системд холбогдох үйл ажиллагаанд 10 сая дирхамын хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлага тавигдана;
- ◆ Компанийн нийт хувьцааны 60–аас доошгүй хувь нь АНЭУ–ын иргэдийн эзэмшилд байх шаардлагатай.

Гадаад валют арилжаа эрхлэгчид нь дараах үүрэг, хариуцлага хүлээнэ:

- ◆ Нийт хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийг 10 дахин нэмэлдүүлснээс хэтрэхгүй байна;
- ◆ Компанийн удирдах албан тушаалтан нь Төв банкнаас баталгаажсан туршлагатай, мэргэжлийн хүн байна;
- ◆ Компанийн эрх зүйн байдал, өмчлөл, байршил зэрэгт өөрчлөлт оруулахын өмнө Төв банкнаас бичгээр зөвшөөрөл авсан байна;
- ◆ Бүх гүйлгээний баримтыг хадгалах, харилцагчдад хангалттай мэдээлэл өгөх үүрэгтэй;
- ◆ AED 3,500 –оос давсан арилжаанд харилцагчийг таньж баталгаажуулах үүрэгтэй.

Төв банк нь гадаад валют арилжаанд дараах стандартуудыг дагаж мөрдөхийг шаарддаг:

- ◆ Тусгай зөвшөөрөл олгох болон үргэлжилсэн үүргийн стандарт;
- ◆ Бизнесийн удирдлага ба засаглалын стандарт;
- ◆ Эрсдэлийн менежмент ба аюулгүй байдлын стандарт;
- ◆ Мөнгө угаахтай тэмцэх стандарт ;
- ◆ Харилцагчийн эрхийг хамгаалах стандарт.

Зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгож, сунгана. Зөвшөөрөл сунгах хүсэлтийг зөвшөөрлийн хугацаа дуусгавар болох хугацаанаас доод тал нь 2 сарын өмнө гаргана.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

Гадаад валютын арилжаа нь олон улсын санхүүгийн зах зээлийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд, мөнгө угаах болон терроризмын санхүүжилтийн өндөр эрсдэлийг агуулдгаараа онцлог. Тиймээс ихэнх улс орнууд энэ төрлийн үйлчилгээг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхийг шаарддаг зохицуулалтын тогтолцоог хэрэгжүүлдэг.

Судалгаанд хамрагдсан Турк, Танзани, Тайланд, АНЭУ зэрэг орнуудын туршлагаас дараах нийтлэг бөгөөд бодлогын ач холбогдол бүхий дүгнэлтүүдийг хийж болно:

Зохицуулалтын байгууллага, тусгай зөвшөөрөл: Бүх улс орнуудад гадаад валютын арилжааг Төв банк, Сангийн яам эсвэл санхүүгийн зохицуулагч агентлаг хариуцан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагааг эрхлүүлдэг. Үүнд урьдчилсан шалгуур, байршлын үнэлгээ, удирдлагын бүтэц зэрэг шалгуур чухал үзүүлэлт болдог.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн босго, ангилал: Үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран хөрөнгийн босго ялгаатай тогтоогддог. Хамгийн өндөр босгыг АНЭУ-д (2–10 сая AED) харин хамгийн бага босгыг Тайланд (30,000 USD хүртэл) болон Монгол Улс (300 сая төгрөг) тавьсан байна. Зарим оронд ангиллын дагуу (A, B, C) ялгах практик түгээмэл хэрэглэдэг.

AML/CFT ба KYC журам: Бүх улс орон AML хуулийг дагаж мөрдөж, тодорхой гүйлгээний дүнгээс дээш арилжаанд харилцагчийг танин (KYC) баталгаажуулах үүрэгтэй. Судалгаанд хамрагдсан улс орны хувьд KYC босго дүн АНЭУ–3,500 AED (~950 USD), Тайланд–50,000 бат (~1,400 USD), Танзани–5,000 USD, Турк–20,000 TL (~510 USD) байна.

Байршлын зохицуулалт ба хяналт: Тайланд, АНЭУ зэрэг оронд арилжааны цэгийн байршлыг хязгаарладаг бол Танзани, Турк зэрэг улсад урьдчилсан үзлэгийн үндсэн дээр зөвшөөрдөг. Харин Монгол Улсын хувьд байршилд хязгаарлалт тогтоогоогүй болно.

Өдөрт хийх арилжааны дээд хэмжээ: Судалгаанд хамрагдсан улсуудаас Тайланд улс ГВА-ны 1–5-р ангиллын этгээдүүд: 800,000 бат (~22,000 USD), 6-р ангиллын этгээдүүд: 200,000 бат (~5,500 USD)-ын арилжааг өдөрт хийнэ. Харин бусад орнууд (Турк, Танзани, АНЭУ) дээд хязгаарыг тусгайлан тогтоогоогүй боловч AML/CFT хүрээнд тайлагнал болон хяналтын механизмыг хэрэгжүүлэн ажилладаг.

Үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлагууд: Тохиромжтой этгээдийн шалгуур, Аюулгүй байдал хангасан камержуулалт болон Ил тод байдал хангасан мэдээлэл (валютын ханш, хураамжийн мэдээлэл, тусгай зөвшөөрөл гэх мэт), хаягжуулалт харагдахаар тэмдэглэнэ.

Олон улсын туршлага болон Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан дараах бодлогын чиглэлээр зохицуулалтыг сайжруулах санал гаргаж байна:

Ангилал тогтоох, нэршил ялгах: Турк, Танзани загвараар "A", "B", "C" ангилал нэвтрүүлж, хүрээ бүрд хөрөнгийн босго болон зөвшөөрөгдөх үйл ажиллагааг ялган тодорхойлно.

Үйл ажиллагааны явц дахь зохицуулалт: Валютын гүйлгээ нь тусгай зориулалтын касс болон дансаар дамжин хийгдэх бөгөөд бүртгэлтэй, хяналттай байх шаардлагатай. Камер, дүрс бичлэгийн систем нь тодорхой хугацаанд хадгалагдах бөгөөд Турк Улсын жишгийн дагуу 6 сар ба түүнээс дээш хугацаагаар хадгалахыг шаардах; гэмтэл гарсан тохиолдолд засвар, мэдэгдэл, бүртгэлийн баримтжуулалт хийх журамтай байх.

Байршилд хязгаарлалт тогтоох боломжууд:

⇒ Урьдчилсан үзлэг, байршлын баталгаажуулалт (Танзани, АНЭУ-ын туршлага);

⇒ Орон сууцны байранд байршихыг хориглох;

- ⇒ Нийтийн хандалт сайтай, аюулгүй байршилд төвлөрүүлэх;
- ⇒ Хэт төвлөрлийг бууруулах зорилгоор шинэ салбар нээхийг шат дараатай хязгаарлах (Турк Улсын туршлага);
- ⇒ Дижитал арилжаа, автомат төхөөрөмж ашиглах: Зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл этгээдүүдэд автомат төхөөрөмж (АТМ), валют арилжааны киоск машин ашиглан валют арилжаа хийхийг зөвшөөрөх;
- ⇒ Арилжааны төрөл, хязгаарлах;
- ⇒ Үйл ажиллагааны төрлөөс шалтгаалан валют арилжааны байгууллагууд нь зөвхөн спот арилжаа хийх эрхтэй байх бөгөөд ирээдүйн огноотой, форвард, своп зэрэг арилжааны хэлбэрийг хориглох;
- ⇒ Өдөрт хийх гүйлгээний дээд хязгаарыг тогтоох шаардлагагүй ч, AML/CFT журмаар өндөр дүнгийн арилжаанд хяналт тавих;
- ⇒ Зохицуулалтын гүйцэтгэлийн хяналт;
- ⇒ Мөрдөгдөж буй эрх зүйн орчны хэрэгжилт, хяналтын үр нөлөөг сайжруулах;
- ⇒ Зохицуулах байгууллагуудын тайлагналын ил тод байдлыг нэмэгдүүлж;
- ⇒ Мэдээлэл солилцоо, цахим хяналтын системийг хөгжүүлэх.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ Монгол Улсын хууль, Валютын зохицуулалтын тухай, 1994.  
Эх үүсвэр: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=127>;
- ◆ Монгол Улсын хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, 2002.  
Эх үүсвэр: <https://www.frc.mn/resource/frc/Document/2020/04/23/7w14vxm2am63fq0a/3521009dea302fb2729708de1a19cd3472118ce0%201.pdf>;
- ◆ Санхүүгийн зохицуулах хороо, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам, 2025.  
Эх үүсвэр: <https://www.frc.mn/resources/Image/Document/202504/NePAv/68+78.pdf>;
- ◆ Bank of Tanzania, The foreign exchange act, 2023.  
Retrieved from: <https://www.bot.go.tz/Publications/Acts,%20Regulations,%20Circulars,%20Guidelines/Regulations/en/2023101310363815.pdf>;
- ◆ Bank of Thailand, Rules and Practices regarding the Undertaking of Authorized Money Changers, 2004.  
Retrieved from: <https://www.bot.or.th/en/our-roles/financial-markets/foreign-exchange-regulations/foreign-exchange-business/authorized-money-changers.html>;
- ◆ Central Bank of the U.A.E, Regulations Re Licensing and Monitoring of Exchange Business, 2014.  
Retrieved from: <https://rulebook.centralbank.ae/en/rulebook/regulations-re-licensing-and-monitoring-exchange-business>.
- ◆ The Financial Action Task Force, Money Laundering through Money Remittance and Currency Exchange Providers, 2010.  
Retrieved from: <https://www.fatf-gafi.org/en/publications/Methodsandtrends/Moneylaunderingthroughmoneyremittanceandcurrencyexchangeproviders.html>;
- ◆ Turkey official gazette, Regarding the Protection of the Value of Turkish Currency, 2018.  
Retrieved from: [https://ms.hmb.gov.tr/uploads/sites/2/2018/12/Exchange-Offices-Legislation-of-Turkey-Communique-No.-2018-32-45-attached-to-the-Decree-32\\_07092018.docx](https://ms.hmb.gov.tr/uploads/sites/2/2018/12/Exchange-Offices-Legislation-of-Turkey-Communique-No.-2018-32-45-attached-to-the-Decree-32_07092018.docx); to Smart

Та бүхэнд санхүүгээ зөв удирдах **5 ЧУХАЛ ДАДАЛ**, мөн санхүүгийн хувьд хүмүүсийн түгээмэл гаргадаг **5 АЛДААГ** танилцуулъя.



## САНХҮҮГЭЭ ЗӨВ УДИРДАХ 5 ДАДАЛ

### Мөнгөн урсгалаа бүртгэх



Орлого, зарлагаа тогтмол бүртгэж, санхүүгийн урсгалаа хянах.

### Төлөвлөж худалдан авалт хийх



Том худалдан авалт хийхээс өмнө **24-48 цаг** бодож шийдвэр гаргах.

### Жижиг зардлаа хязгаарлах



Өдөр, долоо хоногт зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох.

### Автомат шилжүүлэг ашиглах



Тогтмол зардал ба хадгаламжийг автоматаар татах тохиргоо хийх.

### Нэмэлт орлогын хуваарилалт



Бонус, бэлэг зэрэг нэмэлт орлогыг хөрөнгө оруулалт, гэнэтийн хэрэгцээнд зориулж хуримтлал хийх.

# САНХҮҮГЭЭ УДИРДАХАД ГАРГАДАГ ТҮГЭЭМЭЛ 5 АЛДАА

## Төлөвлөлтгүй худалдан авалт



Хэрэгцээгүй зүйлсийг сэтгэл хөдлөлөөр эсвэл "шинэ загвар", "хямдрал" зарласан гэх шалтгаанаар худалдан авалт хийх.

## Хуримтлал үүсгэхээс зайлсхийх



"Дараа хадгална" гэж байнга хойшлуулах, орлогоос үлдсэнийг хадгална гэж төлөвлөх.

## Өрийн дарамтад орох



Зээлийг анх авсан зорилгоос өөр зүйлд (хэрэгцээгүй худалдан авалт, зугаа, тансаг хэрэглээ) зарцуулах, нэмж зээл авах.

## Жижиг зардлыг үл тоох



Өдөр тутам давтагддаг гардаг жижиг зардлуудыг анзаарахгүй өнгөрөөх. Жишээлбэл, кофе, такси, амттан, аппликейшны захиалга.

## Хүсэл ба хэрэгцээг ялгахгүй байх



Зайлшгүй хэрэгцээнээс илүү, түр зуурын хүсэл болон трендийг бодит хэрэгцээтэй андуурч худалдан авалт хийх.

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

**ШВЕЙЦАРИЙН БАНКНУУД ШВЕЙЦАРИЙН ФРАНКААР БАТАЛГААЖСАН СТЕЙБЛКОЙНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ БОЛОМЖУУДЫГ ТУРШИНА.**



Швейцарийн зургаан банк швейцарийн франкаар баталгаажсан стейблкойныг санхүүгийн бодит хэрэглээнд хэрхэн ашиглаж болохыг Swiss Stablecoin AG компанитай хамтран сэндбокс орчинд туршихаар болсон.

Энэхүү санаачилгад UBS, PostFinance, Sygnum, Raiffeisen, ZKB, BCV оролцож байгаа бөгөөд цаашид бусад банк нэгдэх боломжтой байна. UBS-ийн тайлбарласнаар, Швейцарт одоогоор өргөн хэрэглээнд зориулагдсан, зохицуулалттай швейцарийн франкаар баталгаажсан стейблкойн байхгүй байгаа тул 2026 онд хэрэгжих энэ туршилтыг виртуал мөнгөний экосистемийг бэхжүүлэх алхам гэж үзэж байна.

Стейблкойн нь уламжлалт валютаар баталгаажсан, үнэ цэнээ тогтвортой хадгалах зорилготой крипто хөрөнгө бөгөөд сүүлийн жилүүдэд банкнууд энэ зах зээлийг улам идэвхтэй сонирхох болсон. Reuters-ийн мэдээлснээр, Европ болон АНУ-ын томоохон банкнууд ч өөрсдийн стейблкойн гаргах, эсвэл ийм төрлийн дижитал төлбөрийн шийдлийг турших боломжийг судалж байна.

Сүүлийн жилүүдэд стейблкойны зах зээл эрчимтэй тэлсэн ч уг зах зээлд Эл Сальвадорд төвтэй Tether компани давамгайл байр суурь эзэлсэн хэвээр байна. Харин банкнуудын гаргасан стейблкойны эрэлт одоогоор бага байна.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

**ХОНГКОНГТ СТЕЙБЛКОЙН ГАРГАХ АНХНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮДИЙГ ОЛГОВ.**



Хонгконгийн Мөнгөний бодлогын газар уламжлалт мөнгөн тэмдэгтээр баталгаажсан стейблкойн гаргах анхны тусгай зөвшөөрлүүдийг олгосон нь тус бүс нутагт зохицуулалттай виртуал валютын тогтолцоог хөгжүүлэх бодлогын хүрээнд хийгдэж буй чухал алхам боллоо. Уг зөвшөөрлийг HSBC банк болон Standard Chartered-ийн хамтарсан компани болох Anchorpoint Financial-д олгосон. Дээрх байгууллагууд Хонгконг долларт суурилсан стейблкойныг 2026 оны хоёрдугаар хагаст зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үүнийг гадаад болон дотоод төлбөр тооцоо, мөн түүнчлэн виртуал хөрөнгийн арилжаанд ашиглахаар зорьж байна. HSBC банк өөрийн stablecoin-ийг PayMe болон HSBC HK Mobile Banking гар утасны аппликейшнээр дамжуулан хэрэглээнд нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа бол Anchorpoint Financial нь стейблкойноо олон нийтэд хүргэх зорилгоор сонгогдсон аж ахуйн нэгжүүдтэй түгээлтийн хэлбэрээр хамтран ажиллахаа мэдэгджээ.

Анхны тусгай зөвшөөрлийг уламжлалт банкнуудад олгосон нь Хонгконг олон улсын виртуал хөрөнгийн төв болох зорилгоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ мөнгө угаах болон санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой эрсдэлийг хяналттай авч үзэж байгааг илэрхийлж байна. Мөнгөний бодлогын газрын дэд захирал Дэрил Хо цаашид нэмэлт зөвшөөрөл олгох асуудалд нээлттэй боловч болгоомжтой хандана хэмээн мэдэгдэж, шинээр олгох зөвшөөрлийн тоо маш хязгаарлагдмал байна гэдгийг онцолжээ. Тус байгууллага өнгөрсөн онд нийт 36 өргөдөл хүлээн авсан.

Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)

**ОЙРХ ДОРНОДЫН ДАЙН ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙНА.**



Олон Улсын Валютын сангаас Ойрх Дорнод дахь дайн нь зөвхөн бүс нутгийн зөрчил биш, харин дэлхийн санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлөх хэмжээний эрсдэл болж байгааг анхааруулсан. Тус мөргөлдөөний улмаас газрын тос болон бусад эрчим хүчний бүтээгдэхүүний үнэ өсөж, үүнийг дагаад инфляцын дарамт нэмэгдэж, санхүүгийн зах зээлийн нөхцөл чангарч болзошгүй гэж үзжээ. Үүний нөлөөгөөр дэлхийн хувьцааны ханш буурч, улсын бондын өгөөж өсөхийн зэрэгцээ хөрөнгө оруулагчдын эрсдэлээс зайлсхийх хандлага нэмэгдэж байгааг онцоллоо.

Мөн өндөр өртэй улс орнууд, хөшүүрэг их ашигладаг хөрөнгө оруулагчид, хувийн зээлийн зах зээл болон хиймэл оюун ухаантай холбоотой санхүүжилт татдаг компаниуд илүү эмзэг байдалд орж болзошгүйг дурдсан. Ялангуяа санхүүгийн нөхцөл огцом чангарах тохиолдолд хөрөнгийн албадан худалдаа, хөрвөх чадварын хүндрэл, зээлийн эрсдэл нэмэгдэх магадлалтай гэж дүгнэжээ. Иймээс бодлого боловсруулагчид инфляц, өрийн тогтвортой байдал, зах зээлийн хөрвөх чадвар болон санхүүгийн салбарын эрсдэлийг илүү нягт хянаж, шаардлагатай тохиолдолд дэмжлэг үзүүлэх бодлогын хэрэгслээ урьдчилан бэлэн байлгах хэрэгтэй гэж ОУВС зөвлөсөн.

*Эх сурвалж: [www.reuters.com](http://www.reuters.com)*

WORLD FINANCE

